



МОНГОЛ УЛСЫН САНХҮҮГИЙН САЛБАРТ ГАДААДЫН БАНК ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХАД АНХААРАХ ЗҮЙЛС

ГАРЧИГ

Оршил	3
1. Хууль, эрх зүйн орчин: Зохицуулалт, хязгаарлалт	6
1.1 Банкны тухай хууль.....	6
1.2 Хөрөнгө оруулалтын тухай хууль.....	6
1.3 Банкны зөвшөөрлийн журам.....	6
1.4 Хөрөнгө оруулалтын банкны тухай хуулийн төслийн талаар.....	7
1.5 Бусад орны хязгаарлалт, зохицуулалт.....	8
2. Санхүүгийн салбарт үзүүлэх нөлөө	9
2.1 Монгол Улсын санхүүгийн салбарын өнөөгийн байдал.....	9
2.2 Олон улсын туршлага.....	9
2.3 Банкны салбарт үзүүлэх нөлөө: харьцуулсан шинжилгээ.....	11
3. Эдийн засагт үзүүлэх нөлөө	13
3.1 Олон улсын туршлага.....	13
3.2 Монгол Улсын макро эдийн засагт үзүүлэх нөлөө.....	15
4. БНХАУ-ын туршлага	16
4.1 Гадаадын банкны хууль, эрх зүйн зохицуулалт.....	16
4.2 БНХАУ-ын банкуудын гадаадад явуулж буй үйл ажиллагаа.....	16
5. Дүгнэлт, цаашид авах арга хэмжээний санал	18
Ашигласан материал	21

ОРШИЛ

Дэлхийн эдийн засгийн интеграцчилал эрчимжихийн хэрээр санхүүгийн зах зээлийн либералчлал улам бүр тэлж байна. Үүнтэй холбоотойгоор сүүлийн 30 гаруй жилийн турш хөгжиж буй, шилжилтийн эдийн засагтай болон

шинээр бий болсон орнуудын банкны салбар дахь гадаадын хөрөнгө оруулалтын хувь, хэмжээ эрс өсч, гадаадын банкуудын тоо огцом нэмэгдсээр байна.

Хүснэгт 1: Гадаадын банкны тоо, активын хэмжээ /хувиар/

	Гад. банкны тоо/Нийт банкны тоо				Гад. банкны актив/Нийт актив			
	1990-95	2000-05	2010-15	Тренд	1990-95	2000-05	2010-15	Тренд
Зүүн Ази ба Номхон далайн орнууд								
БНХАУ	0	7	20	↗	0	1	2	↗
Камбож	25	39	61	↗	0	27	59	↗
Малайз	27	31	41	↗	25	18	17	↘
Филиппин	12	15	12	↘	8	1	1	↘
БНСУ	1	11	13	↗	2	20	7	↘
Индонез	24	31	48	↗	4	27	25	↘
Зүүн Европ ба Төв Азийн орнууд								
Хорват	2	31	50	↗	2	89	90	↗
Чех	42	55	63	↗	17	84	83	↗
Унгар	49	75	81	↗	19	77	61	↘
Польш	22	69	76	↗	4	74	74	↗
Словен	15	26	36	↗	5	23	25	↗
Латин Америк ба Карибын тэнгисийн орнууд								
Бразил	21	21	17	↘	9	37	39	↗
Мексик	83	76	72	↘	2	40	41	↗
Колумб	15	13	13	↘	6	32	39	↗
Аргентин	28	27	28	↘	26	33	32	↘
Ойрхи Дорнод ба Африкын орнууд								
Египет	11	24	23	↗	4	52	54	↗
Өмнөд Африк	25	26	25	↗	0	23	24	↗
Судан	1	15	9	↗	0	24	21	↘
Нигер	2	3	18	↗	10	15	25	↗

Эх сурвалж: Дэлхийн банк

Бүс нутгаар салган авч үзвэл Зүүн Ази ба Номхон далайн орнуудын хувьд гадаадын банкуудын тоо нэмэгдсэн хэдий ч нийт банкны салбарт эзлэх активын хэмжээ төдийлөн нэмэгдээгүй байна. Зүүн Европын орнуудад банкны салбарын активын дийлэнх буюу 50-иас дээш хувийг гадаадын банкууд эзэлж байна. Харин энэ үзүүлэлт Латин Америкийн орнуудын хувьд дунджаар 40%, Ойрхи Дорнод ба Африкийн орнуудын хувьд дунджаар 25% байна.

Гадаадын банкуудын үйл ажиллагааны зорилго, хэлбэр, хамрах хүрээ нь харилцан

адилгүй байдаг. Тухайлбал, Латин Америк, Зүүн Европ болон Африкийн хөгжиж буй орнуудад гадаадын банкууд дотоодын банкуудын дүрмийн санд хөрөнгө оруулах, худалдаж авах, нэгдэх замаар нэвтэрсэн тохиолдол түгээмэл байдаг бол Зүүн Азийн орнуудад охин компани, салбар, нэгж байгуулах замаар үйл ажиллагаа явуулж байна.

Гадаадын банкууд үйл ажиллагаагаа олон улсад ийнхүү тэлж байгаа нь дараах хэд хэдэн зорилготой байна.


Гадаадын банкны хувьд	Хүлээн авагч улсын хувьд
<ul style="list-style-type: none"> Гадаад хэрэглэгчдэдээ хүрч ажиллах; Татварын таатай орчин эрэлхийлэх; Эрсдэлээ тараан байршуулах; Хөрөнгө оруулалтын өгөөж өндөр улсуудад орж ашгаа нэмэгдүүлэх; Төрийн банкууд нь улсынхаа бодлого, үйл ажиллагааг нэвтрүүлж, хэрэгжүүлэх; 	<ul style="list-style-type: none"> Гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх; Банкны салбарт хямд өртөгтэй, урт хугацаатай эх үүсвэр татах; Төрийн өмчит банкуудыг хувьчлах; Санхүүгийн гүнзгийрлийг нэмэгдүүлэх; Санхүүгийн зуучлалын үр ашгийг сайжруулах;

Олон улсын түвшинд хийгдсэн судалгааны үр дүнд гадаадын банкны нөлөө хөгжингүй болон хөгжиж буй орнуудад харилцан адилгүй гэсэн ерөнхий дүгнэлтэд хүрсэн байдаг.

- Хөгжингүй орнуудын хувьд санхүүгийн салбарын хөгжил өндөр тул (өрсөлдөөн, шинэлэг технологи, бүтээгдэхүүн, үйлчилгээ, тогтвортой байдал) гадаадын банк нэвтэрснээр харьцангуй бага нөлөө үзүүлдэг.

- Харин хөгжиж буй орнуудын хувьд санхүүгийн салбарын хөгжил харьцангуй сул байдаг тул хүчтэй нөлөө үзүүлдэг байна.

Гадаадын банкууд орж ирснээр санхүүгийн салбарын үр ашиг, хөгжил, тогтвортой байдал болон макро эдийн засагт тодорхой нөлөө үзүүлдэг.



- ◇ Банкны зардал, ашигт ажиллагаа болон зуучлалын өртгөөр дамжуулан банкны салбарын үр ашигт нөлөөлдөг.
- ◇ Өрхийн банкны үйлчилгээ, ААН-ийн зээл олголт, хөрөнгө оруулалтаар дамжуулан санхүүгийн хүртээмжид нөлөөлдөг.
- ◇ Зөвхөн зээлийн зах зээлд бус хөрөнгийн зах зээлд нэвтэрч санхүүгийн гүнзгийрэлд нөлөөлөх боломжтой.

- ◇ Мөнгөний бодлогын шилжих механизмаар болон гадаад нөлөөг дамжуулах замаар эдийн засаг, санхүүгийн тогтвортой байдалд нөлөөлдөг.

Гадаадын банк орж ирснээр дотоодын эдийн засаг, санхүүгийн салбарт дараах эерэг болон сөрөг нөлөөг үзүүлдэг байна.

Эерэг нөлөө	Сөрөг нөлөө
<ul style="list-style-type: none"> ■ Олон улсын санхүүгийн зах зээлийн интеграцчилалд нэгтгэх; ■ Санхүүгийн зах зээлийг хөгжүүлж, дэд бүтцийг сайжруулах; ■ Өрсөлдөөнийг бий болгож, үр ашгийг нэмэгдүүлэх; ■ Гадаад санхүүжилтээр зах зээлд бий болсон сөрөг шокыг зөөлрүүлэх; ■ Гадаад санхүүжилт татах замаар валютын урсгалыг нэмэгдүүлэх; ■ Шинэ техник, технологи, үйлчилгээ нэвтрүүлэх; 	<ul style="list-style-type: none"> ■ Гадаад орчны хүндрэлийг дамжуулан тогтвортой байдлыг алдагдуулах; ■ Банкны салбарт өөрийн давамгайл байдлыг бий болгох; ■ Дотоодын бодлого, зохицуулалтыг сулруулах, үр ашгийг багасгах; ■ Стратегийн ач холбогдолтой төслүүдийг хяналтандаа авах; ■ Жижиг, дунд аж ахуйн нэгжүүдийн зээл буурах; ■ Эдийн засгийн мөчлөгийн далайцыг нэмэгдүүлэх; ■ Өрсөлдөөн хэт ихсэж зээлийн нөхцөл суларснаар чанар нь муудах; ■ Дотоодын банкуудын ашигт ажиллагааг бууруулах;

Бусад улсын туршлага, өөрийн орны онцлогийг харгалзан гадаадын банкныг оруулахдаа дараах зүйлсийг анхаарах шаардлагатай байна. Үүнд:

- ◇ Эдийн засгийн ямар үе, мөчлөгт (хямрал, халалт, г.м) гадаадын банкныг дотоодын санхүүгийн зах зээлд оруулж ирэх;
- ◇ Гадаадын банктай холбоотой хууль, эрх зүйн орчинг хэрхэн бүрдүүлэх;
- ◇ Банкны хяналт, шалгалтын хүрээнд гадаадын банкны эрхлэх үйл ажиллагаанд ямар хязгаарлалт, зохицуулалт хийж өгөх;

- ◇ Гадаадын банк орж ирснээр дотоодын эдийн засаг, санхүүгийн салбарт хэрхэн нөлөөлөх талаар нарийн тооцоо, судалгаа хийх;
- ◇ Төрийн өмчит (бодлогын) гадаадын банк орж ирснээр үндэсний аюулгүй байдалд ямар нөлөө үзүүлэх талаар нухацтай авч үзэх зэрэг болно.

1 ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН: ЗОХИЦУУЛАЛТ, ХЯЗГААРЛАЛТ

Олон улсын жишиг, Монгол улсын хууль тогтоомжийн дагуу гадаадын банк нь дотоодын банкны хувьцааг худалдан авч болохын зэрэгцээ төлөөлөгчийн газар, салбар, охин компани (банк) зэрэг төлөөлөл болон бие даасан хэлбэрээр үйл ажиллагаа явуулж болно. Монгол улсад гадаадын банк үйл ажиллагаа эрхлэхэд дараах хууль, журмаар зохицуулагдах боломжтой байна.

1.1 БАНКНЫ ТУХАЙ ХУУЛЬ

- Банк үүсгэн байгуулах зөвшөөрөл авахдаа холбогдох баримт бичгийг Монголбанкинд ирүүлнэ (20). Монголбанк 60 хоногийн дотор зөвшөөрөл олгох эсэх тухай шийдвэр гаргаж мэдэгдэнэ.
- Гадаадын хөрөнгө оруулалттай банк, түүний нэгжийн үйл ажиллагаанд тавих нэмэлт шаардлагыг Монголбанкны журмаар тогтооно (22.2).
- Үйл ажиллагаа эрхлэхдээ Монголбанкнаас тусгай зөвшөөрөл авна (6.1).
- Банкны 5 хүртэлх хувийн хувьцааг худалдан авах бол Монголбанкинд бичгээр тухай бүр мэдэгдэнэ (36.1).
- 5 болон түүнээс дээш хувийг худалдан авах бол өмчлөх эрх шилжихээс өмнө Монголбанкинд бичгээр мэдэгдэж, урьдчилан зөвшөөрөл авна (36.2).

1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬ

- Банкны нийт гаргасан хувьцааны 33 буюу түүнээс дээш хувийг гадаадын төрийн өмчит хуулийн этгээд эзэмшихээр бол хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад зөвшөөрөл хүсэх хүсэлтээ гаргана (21, 22). Тухайн байгууллага 45 хоногийн дотор шийдвэр гаргаж мэдэгдэнэ.

Дээрхээс харахад гадаадын банкны Монгол улсад үйл ажиллагаа явуулах эрх нь Монголбанкинд мэдэгдэж, холбогдох баримт бичгийг бүрдүүлэн, зөвшөөрөл авсны дараа нээлттэй болно (Гадаадын банк нь төрийн өмч давамгайлсан бол Засгийн газраас зөвшөөрөл авсны дараа Монголбанкинд хандана). Монголбанкнаас зөвшөөрөгдсөн “тусгай зөвшөөрөл”-ийн хүрээнд үйл ажиллагаа явуулна. Харин дотоодын банкуудын хувьцааг худалдан авах бол Монголбанкинд бичгээр мэдэгдэж, урьдчилан зөвшөөрөл авна.

Монголбанкнаас гадаадын хөрөнгө оруулалттай банк, банкны салбар, төлөөлөгчийн газар байгуулах, тэдгээрийн үйл ажиллагааг зохицуулах тусгайлан баталсан журам байхгүй бөгөөд уг үйл ажиллагааг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2012 оны А-80 дугаар тушаалаар баталсан “Банкны зөвшөөрлийн журам”-ын хүрээнд зохицуулж байна.

1.3 БАНКНЫ ЗӨВШӨӨРЛИЙН ЖУРАМ

- Гадаадын банк гэж гадаад улсад үүсгэн байгуулагдсан банкнаас 100 хувийн хөрөнгө оруулсан, Банкны тухай хууль тогтоомжийн дагуу Монголбанкны олгосон тусгай зөвшөөрлийг үндэслэн Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж байгаа банкныг хэлнэ (1.5.7).
- Гадаадын банк нь активын хэмжээгээр дэлхийд дээгүүр ордог, зэрэглэл өндөртэй, бусад орнуудад үйл ажиллагаа явуулсан туршлагатай, хууль журам зөрчиж байгаагүй, санхүү болон төлбөрийн чадварын хүндрэлд орж байгаагүй, төлөөлөгчийн газар нь нэгээс доошгүй жил ажилласан зэрэг нэмэлт шаардлагуудыг хангасан байх ёстой (2.3).
- Гадаадын банк байгуулахад үүсгэн

байгуулагчийн шийдвэр, харьяалах улсын эрх бүхий байгууллагын зөвшөөрөл, хяналт шалгалтын талаар хамтран ажиллах албан тоот, сүүлийн 3 жилийн аудитын тайлан, зохистой харьцааны үзүүлэлтүүдийн биелэлтийн тодорхойлолт болон бусад шаардлагатай баримт бичиг, лавлагааг Монголбанкинд ирүүлэх ёстой (2.4).

- Монголбанкны Ерөнхийлөгчийн шийдвэрээр Банкны тухай хуулийн 6.1-т заасан үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг үйл ажиллагааны төрөл тус бүрээр олгоно (4.1).
- Тусгай зөвшөөрөл олгохдоо банкны бизнес төлөвлөгөө, үйл ажиллагааны чиглэл, бүтэц зохион байгуулалт, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, хүний нөөц, ажлын байр, техник, тоног төхөөрөмж, шаардлага хангасан нөөц төв, программ хангамжийн бэлтгэгдсэн байдал зэргийг харгалзан үзэж, эрхлэх үйл ажиллагааны төрөл тус бүр дээр тодорхой хязгаарлалт, хугацаа тогтоож болно (4.2).

Эндээс харахад Монголбанкны журмаар гадаадын банкны тодорхойлолт, түүнд тавигдах нэмэлт шаардлагууд, шаардлагатай бусад баримт бичиг, лавлагааны талаар болон тусгай зөвшөөрөл олгох талаар уян хатан зохицуулж тусгасан байна.

1.4 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАНКНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААР

- Гадаадын банкиг зөвхөн хөрөнгө оруулалтын чиглэлээр дотоодын зах зээлд нэвтрэхийг зөвшөөрөх, ингэхдээ томоохон төсөл санхүүжүүлэхэд шаардлагатай зээлийг гагцхүү хуулийн этгээдэд олгох, гадаад дотоод төлбөр тооцоог гүйцэтгэх, зээлийн баталгаа батлан даалт гаргах, үнэт цаас худалдах, худалдан авахыг

зөвшөөрч, бусад үйл ажиллагааг тэр тусмаа иргэдийн хадгаламж авах зэргийг хориглосон.

- Төслийн зорилго нь хөрөнгө оруулалтын банк үүсгэн байгуулах, тусгай зөвшөөрөл олгох болон хөрөнгө оруулалтын банкны эрхлэх үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулах бөгөөд хөрөнгө оруулалтын банкны удирдлага зохион байгуулалт болон энэ хуулиар нарийвчлан зохицуулснаас бусад банкны үйл ажиллагаатай холбогдсон харилцааг Банкны тухай хуулиар зохицуулахаар тусгасан байна.
- Хөрөнгө оруулалтын банкиг үүсгэн байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах болон банкны хувьцаа эзэмших зөвшөөрөл олгох харилцааг Хөрөнгө оруулалтын банкны тухай хууль болон холбогдох бусад хуульд нийцүүлэн Монголбанкны журмаар зохицуулахаар тусгасан байна.
- Банкны тухай хуульд гадаадын банкны эрхлэх үйл ажиллагааны төрөл, чиглэлийг нээлттэй заасан бол энэ төсөлд тодорхой зохицуулалт, хязгаарлалт хийж өгсөн нь цаашид дээрх хоёр хууль зөрчилдөх нөхцөлийг бүрдүүлж байна.
- Төсөлд гадаадын банкны үйл ажиллагааг Монголбанкнаас тусгайлан хянан зохицуулах асуудлыг банкны хууль тогтоомжоор зохицуулахаар тусгасан хэдий ч гадаадын банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг үйл ажиллагаанд нь тохируулан эрх зүйн хувьд оновчтой зохицуулах хэрэгцээ хэвээр хадгалагдаж байна.

1.5 Бусад орны хязгаарлалт, зохицуулалт

Хүснэгт 2: Гадаадын банкны төрөлжилт, хязгаарлалт, зохицуулалт

	Улс	Үйл ажиллагааны зохицуулалт	Үйл ажиллагааны хязгаарлалт
1.	БНХАУ	-Хадгаламж татах, зээл олгох, кредит, дебит карт олгох, баталгаа, батлан даалт гаргах. -Автомашинны зээл олгох зөвшөөрөл байхгүй мөн зарим хязгаарлалтууд байдаг.	-Хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ 1 тэрбум юань. -Юанийн гүйлгээ эрхлэх зөвшөөрөл авахдаа 3 доошгүй жил ү/а эрхэлж, ашигтай ажилласан байх. -Эдгээр банкуудын зээл, хадгаламжийн харьцаа 75%-иас хэтрэхгүй байх.
2.	БНСУ	-Төлөөлөгчийн газар нээснээс хойш 5 хүртэл жилийн дараа нэгжийн зөвшөөрлийг олгодог. -Гадаадын банк байгуулсан орон нутагт зохицуулалт хийдэг.	-Үйл ажиллагаанд нь ямар нэгэн хязгаарлалт тавьдаггүй. -Гадаадын банк, салбар нээхэд харгалзан 100.0 болон 3.0 тэрбум воны дүрмийн сантай байх.
3.	Мьянмар		-1 салбар нээх эрхтэй бөгөөд дотоодын мөнгөн тэмдэгтээр зээл олгохгүй байх. -Иргэдэд санхүүгийн үйлчилгээ үзүүлэхгүй байх.
4.	Энэтхэг	-Туршилтын хугацааны дараа ү/а эрхлэх тусгай зөвшөөрөл олгоно	-Охин компани буюу хараат байх; -Дүрмийн сан 5 тэрбум рупи байх.
5.	Канад	-Охин компани байх (Өмнө нь). -Зээлийн үйлчилгээ, бүх төрлийн үйлчилгээ - 2 зөвшөөрөлтэй.	-Зээлийн үйлчилгээтэй нь хадгаламж татах эрхгүй (зээл авах эрхтэй). -Бүх төрлийн үйлчилгээтэй нь 150,000 \$ доош хадгаламж татах эрхгүй.
6.	Герман	-Төрөлжсөн, бүх ү/а эрхлэх, хязгаарлагдмал- 3 зөвшөөрөлтэй. -Ипотекийн зээлийн, барилгын, хөрөнгө оруулалтын, тусгай зориулалтын гэсэн төрөлжсөн банкууд байдаг.	-Хязгаарлагдмал зөвшөөрөлтэй банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ нь бүрэн зөвшөөрөлтэй банкнаас бага байдаг.
7.	Япон	-Хадгаламж, зээлийн ү/а эрхлэх цар хүрээний хувьд болон бүс нутгийн хувьд төрөлждөг.	

2 САНХҮҮГИЙН САЛБАРТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ

2.1. МОНГОЛ УЛСЫН САНХҮҮГИЙН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Монгол улсад 2016 оны эцсийн байдлаар 14 банк, 500 орчим банк бус санхүүгийн байгууллага, 276 Хадгаламж зээлийн хоршоо, 15 Даатгалын компани, 58 брокер, дилерийн компани үйл ажиллагаа явуулж, нийт санхүүгийн салбарын 96 орчим хувийг банкны салбар дангаараа бүрдүүлж байна.

Гадаадын банк, санхүүгийн байгууллага нь Монголын банкуудад хөрөнгө оруулж, хувь эзэмших хэлбэрээр анх нэвтэрч, өнөөгийн байдлаар нийт 14 банкнаас 8 нь гадаадын хөрөнгө оруулалттай, 3 нь гадаад банкны хувьцаа эзэмшигчтэй байна.

Монгол Улсын санхүүгийн зах зээлд 2008 оноос эхлэн гадаадын банк төлөөлөгчийн газраа байгуулан үйл ажиллагаа явуулж эхэлсэн бөгөөд өнөөдрийн байдлаар тусгай шалгууруудыг хангасан олон улсад нэр хүнд бүхий 5 гадаадын банкны "Төлөөлөгчийн газар" үйл ажиллагаа эрхэлж байна. Монголбанкнаас гадаадын банкны төлөөлөгчийн газруудад:¹

- Зах зээлийн судалгаа хийх;
- Эрх зүйн төлөөллийн үйл ажиллагаа эрхлэх;
- Толгой болон салбар банкаараа дамжуулан дотоодын санхүүгийн байгууллага, ААН-д хямд эх үүсвэртэй санхүүжилт зуучлахыг зөвшөөрсөн.

Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын банкны төлөөлөгчийн газрууд нь бүгд 1-ээс дээш жил үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд одоогоор банкны үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгогдоогүй байна.

БНХАУ-ын төрийн өмчит "Bank of China"-аас банкны үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүсэх тохиолдолд холбогдох хүсэлтээ эхлээд Засгийн газарт гаргаж зөвшөөрсөн тохиолдолд Монголбанкинд ирүүлэх шаардлагатай.

2.2. ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА

Сүүлийн 20 жилийн хугацаанд гадаадын томоохон банкууд өргөжин тэлж хөгжиж буй ихэнх орнууд, тэр дундаа шилжилтийн эдийн засагтай улсуудад санхүүгийн (банкны) үйл ажиллагаагаа явуулах болжээ. Судлаачдын улс орнуудыг харьцуулсан судалгаагаар гадаадын банкны үйл ажиллагаа нь тухайн орны газар зүйн байршил, макро эдийн засгийн нөхцөл байдал, банк санхүүгийн хөгжил, хэрэгжүүлж буй бодлого болон үйл ажиллагаа, хууль эрх зүйн орчин зэргээс хамаарч тухайн орны эдийн засагт үзүүлэх нөлөө нь харилцан адилгүй байдаг гэсэн үр дүнд хүрсэн байдаг.

¹ ING Bank (татан буугдсан), Bank of China, Sumitomo Mitsui Banking Corporation, Bank of Tokyo Mitsubishi UFJ, Industrial and Commercial Bank of China

Хүснэгт 3: Гадаадын банкны санхүүгийн салбарт үзүүлсэн нөлөөлөл

Улс	Судлаач	Дотоодын банкны салбарт үзүүлсэн нөлөө
Төв ба Зүүн Азийн улс орнууд		
БНСУ	Lee (2003)	<ul style="list-style-type: none"> Өрсөлдөөн нэмэгдэж, дотоодын банкуудын зардлын үр ашигт байдал сайжрахад нөлөөлсөн.
	Kim, Lee нар (2004)	<ul style="list-style-type: none"> Томоохон ААН-д түлхүү зээл олгох болсноор жижиг, дунд ААН зээл авахад хүндрэлтэй болж эхэлсэн.
БНХАУ	Xin (2006)	<ul style="list-style-type: none"> Зах зээлийн өрсөлдөөн нэмэгдэж, үр ашиг сайжирсан
	Li (2011) Shi Chao, Park (2012)	<ul style="list-style-type: none"> Богино хугацаанд ашигт ажиллагаанд сөргөөр нөлөөлсөн. Дунд, урт хугацаанд дотоодын банкуудын өрсөлдөх чадвар сайжирч ашигт ажиллагаанд эерэгээр нөлөөлсөн.
Энэтхэг	Bhat (2009)	<ul style="list-style-type: none"> Ү/А-ны зардлыг өсгөж, ашигт ажиллагааг бууруулсан Томоохон ААН-д зээл олгох хандлага нэмэгдсэн.
Индонез	Hamada (2013)	<ul style="list-style-type: none"> Ашигт ажиллагаа, хүүний зөрүүнд* сөргөөр нөлөөлсөн. ЖДҮ-ийн зээлд мөн сөрөг нөлөөтэй байсан.
Тайланд	Okuda (2005)	<ul style="list-style-type: none"> Зардлыг нэмэгдүүлсэн, ашигт ажиллагааг бууруулсан.
Төв ба Зүүн Европын улс орнууд		
ОХУ	Serdyuk (2004)	<ul style="list-style-type: none"> Өрсөлдөөн нэмэгдэж хүүний зөрүү, ашиг буурсан. Хүүний бус орлогыг нэмэгдүүлэх нөлөө үзүүлсэн.
Украйн	Serdyuk (2004), Tsaruk (2008)	<ul style="list-style-type: none"> Банкуудын ашигт ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлээгүй. Хүүний зөрүүг нэмэгдүүлсэн.
	Mikolajczyk, Miklaszewska нар (2009)	<ul style="list-style-type: none"> Өрсөлдөөний орчныг сайжруулж, дунд, урт хугацаанд дотоодын банкуудын үйл ажиллагаа шинэчлэгдэх, ашигт ажиллагаа болон үр ашиг сайжрахад нөлөөлсөн.
Турк	Denizer (2000), Degirmen (2011)	<ul style="list-style-type: none"> Өрсөлдөөнийг нэмэгдүүлж, үр ашигт эерэгээр нөлөөлсөн. Санхүүгийн тогтвортой байдалд эерэгээр нөлөөлсөн. Өөрийн хөрөнгийн, хөрвөх чадварын эрсдэл, валютын ханшийн эрсдэлээс сэргийлэхэд эерэг нөлөө үзүүлсэн.
Латин Америкын улс орнууд		
Бразил	Guimarges (2008)	<ul style="list-style-type: none"> Банкууд үр ашигтай ажиллах хандлагатай болсон. Өрсөлдөөнийг нэмэгдүүлж, үр ашигт эерэгээр нөлөөлсөн
Мексик	Haber et al. (2010)	<ul style="list-style-type: none"> Банкны системийн тогтвортой байдалд эерэгээр нөлөөлсөн. Санхүүгийн зуучлал нэмэгдүүлээгүй, хүүний зөрүү өссөн
Африкын улс орнууд		
Гана	Nsiah K (2013)	<ul style="list-style-type: none"> Банкуудын ашигт ажиллагаанд эерэгээр нөлөөлсөн.
Кени	Ben Ukaegbu Isaiah Oino (2014)	<ul style="list-style-type: none"> Ашигт ажиллагаанд сөргөөр нөлөөлсөн. Зээлийн нийлүүлэлтийг нэмэгдүүлсэн. Санхүүгийн тогтвортой байдалд эерэг нөлөө үзүүлсэн.

* Хүүний зөрүү: Зээл, хадгаламжийн хүүний зөрүү


2.3. БАНКНЫ САЛБАРТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ: ХАРЬЦУУЛСАН ШИНЖИЛГЭЭ

Зардлын үр ашигт байдал

Гадаадын банк орж ирснээр банкууд зах зээлээ алдахгүйн тулд техник, технологио шинэчилж олон улсын түвшинд хүргэх, хүүний нөөц, удирдлага, менежментээ сайжруулах, шинэлэг бүтээгдэхүүн, үйлчилгээг харилцагчдадаа санал болгох зэргээр үйл ажиллагааны зардлаа нэмэгдүүлэх талтай юм.

Монголын банкууд дунд, урт хугацаанд зардлын үр ашигт байдлаа сайжруулж, гадаадын банктэй өрсөлдөхүйц түвшинд хүрэхийн тулд богино хугацаанд үйл ажиллагааны зардлаа өсгөх магадлалтай юм. Дотоодын банкуудын үйл ажиллагааны зардал бусад хөгжиж буй орнуудын дундаж түвшинд хүрэхийн тулд өнөөгийн түвшнээсээ 1-1.3 нэгж хувиар өсөхөөр байна.

Зураг 1: Зардлын үр ашигт байдал




Эх сурвалж: Дэлхийн банк, Судлаачдын дүрслэл (Будагдсан хэсэгт банкны системд нь гадаадын банкууд 50 хүртэлх %-ийг эзэлдэг хөгжиж буй орнуудын дундаж утгыг харуулав)

Төвлөрөл

Хөгжиж буй орнуудад гадаадын банкны оролцоо нэмэгдэх нь дунд хугацаанд төвлөрлийг сааруулж, өрсөлдөөнийг нэмэгдүүлэхэд эерэг нөлөө үзүүлдэг.

Манай улсад гадаадын банкууд орж ирснээр дотоодын зах зээлийн төвлөрөл саарч, улмаар 5 том банкны нийт системд эзлэх хувь 17 орчим хувиар буурахад бусад хөгжиж буй улсуудын дундаж түвшинд очих боломжтой байна.

Зураг 2: Төвлөрлийн харьцаа




Эх сурвалж: Дэлхийн банк, Судлаачдын дүрслэл

Зээлийн хүү

Хөгжиж буй орнуудын хувьд гадаадын банк орж ирснээр зээлийн хүүг бууруулах нөлөөтэй байдаг. Монгол улсад гадаадын банк орж ирснээр дунд, урт хугацаанд зээлийн хүү өнөөгийн түвшнээс 4-5 нэгж хувиар буурч хөгжиж буй орнуудын дундаж түвшинд (13.3%) очих боломжтой юм.

Үүний хажуугаар өрсөлдөөн хэт ихсэж, зээлийн нөхцөл суларч улмаар чанаргүй зээл өсөх, мөн гадаадын банкууд мэдээлэл хомс тул системийн эрсдэлийг нэмэгдүүлэх талтай. Гадаадын банкууд эрсдэл багатай том ААН-д зээл олгосноор жижиг, дунд ААН-ийн зээлийн хүү төдийлөн буурахгүй байж болно.

Зураг 3: Зээлийн хүү




Эх сурвалж: Дэлхийн банк, Судлаачдын дүрслэл

Ашигт ажиллагаа

Судалгаануудын үр дүнгээр гадаадын банк нэвтэрснээр өрсөлдөөнийг нэмэгдүүлж улмаар **хүүний зөрүүг** (зээл, хадгаламжийн хүүний зөрүү) бууруулах, үйл ажиллагааны зардлыг өсгөх зэргээр дотоодын банкуудын ашигт ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлдэг.

Хөгжиж буй бусад орнуудын хувьд гадаадын банкуудын зах зээлд эзлэх хувь хэт өндөр болох нь системийн ашигт ажиллагааг бууруулдаг. Монгол Улсын хувьд банкуудын ашигт ажиллагаа сүүлийн 3 жилийн дунджаар 1.3%-тай байгаа нь хөгжиж буй орнуудын дундажтай ойролцоо байна

Зураг 4: Активын өгөөж



Эх сурвалж: Дэлхийн банк, Судлаачдын дүрслэл

3 ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ

3.1. ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА

Санхүүгийн салбарын либералчлал, түүнтэй холбоотой үйл ажиллагаа нь тухайн орны эдийн засгийн хөгжилд эерэг нөлөөтэй гэсэн үзэл давамгайлдаг. Санхүүгийн салбар сайтар хөгжсөн орнуудын нэг хүнд ногдох бодит ДНБ-ий хэмжээ өндөр байдгийг олон тооны судалгаа тогтоосон байдаг. Гадаадын банкууд орж ирснээр тухайн улсын хувьд:

- Гадаад урт хугацааны санхүүжилтийн хэрэгцээ хангагдах;
- Богино хугацаанд зээл олголт өсөх;
- Дотоодын аж ахуйн нэгжүүдийн зээлийн өртөг, зардлыг бууруулж, ашигт ажиллагааг нэмэгдүүлэх;
- Цаашлаад эдийн засгийн идэвхжлийг дэмжих;

зэргээр эерэг нөлөө үзүүлдгийг өргөнөөр хүлээн зөвшөөрдөг. Гадаадын банк орж ирснээр зээлийн хүртээмж нэмэгдэх, санхүүжилтийн өртөг буурах эсэх нь дотоодын банкны салбарын өрсөлдөөний хариу үйлдэл, хөгжлийн түвшнээс хамаардаг байна.

Бусад улсын нийтлэг туршлагаас харахад гадаадын банкууд дотоодын эдийн засагт дараах сөрөг нөлөөллүүдийг үзүүлэх боломжтой. Үүнд:

- Эдийн засгийн өсөлттэй үед орж ирэх, хөрөнгө оруулалтаа ихээхэн хэмжээгээр нэмэгдүүлэх замаар эдийн засгийн мөчлөгийн далайцыг нэмэгдүүлэх буюу эдийн засгийн хэт халалт улмаар хямралыг өдөөх эрсдэлтэй.

- Жижиг зээлдэгч тус бүрийн мэдээллийг олж авахад өндөр зардал гардаг тул мэдээллийн тэгш бус байдал ихтэй бага орлоготой улсын хувьд гадаадын банкууд “жимс түүх буюу cherry-picking” стратегийг баримталж, зээлийн эрсдэл багатай, хамгийн сайн зээлдэгчдэд зээл олгох (өрмийг нь авах буюу cream-skimming) хандлагатай байдаг.
- Ийнхүү гадаадын банкууд дотоодын банкуудын сайн харилцагчдыг булаах, өндөр ашигтай томоохон төслүүдэд хөрөнгө оруулалт хийх нь дотоодын банкны зээлээр гол төлөв санхүүждэг, гадаадаас санхүүжилт татах боломж хязгаарлагдмал, эдийн засгийн өсөлтөд багагүй хувь нэмэр оруулдаг жижиг, дунд аж ахуйн нэгжүүдийг санхүүжилтийн дутагдалд оруулах, тэдний хувьд зээлийн хүртээмжийг бууруулах эрсдэлтэй.
- Мөн банкны салбар дахь өрсөлдөөн нэмэгдсэнээр дотоодын зарим банкуудыг дампууруулах боломжтой. Уг эрсдэл буурай хөгжилтэй, бага орлоготой орнуудын хувьд өндөр байдаг.
- Дунд, урт хугацаанд тухайн улсын макро бодлого, мөнгөний бодлогын шилжих механизмыг сулруулж, дотоодын эдийн засгийг олон улсын санхүүгийн зах зээлийн шоконд мэдрэмтгий болгодог.

Хүснэгт 4: Гадаадын банкны эдийн засагт үзүүлсэн нөлөө (улсуудаар)

Улс	Туршлага
Латин Америкийн орнууд	
Аргентин	<ul style="list-style-type: none"> 1997 оны байдлаар гадаадын банкууд нийт олгосон зээлийнхээ 95%-ийг тус улсын аж үйлдвэр, тоног төхөөрөмжийн салбар дахь үндэсний томоохон аж ахуйн нэгжүүдэд олгосон байв.
Мексик	<ul style="list-style-type: none"> Тус улс дахь гадаадын банкууд дотоодын банкуудтай харьцуулахад харьцангуй бага хүү санал болгож байсан нь тус улсын иргэд, аж ахуйн нэгжүүд, цаашлаад эдийн засагт нь эерэг нөлөө үзүүлсэн байна.
Зүүн-Өмнөд Азийн орнууд	
Энэтхэг	<ul style="list-style-type: none"> Энэтхэг дэх гадаадын банкуудын 75% нь Дели, Бомбей, Калькутта гэсэн гурван том хотод төвлөрсөн байх ба нийт олгосон зээлийнхээ 80%-ийг аж үйлдвэр, худалдааны салбарын томоохон ААН-үүдэд олгожээ. Тус улсын хувьд гадаадын банкууд орж ирснээр зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх бус зөвхөн цөөн хэмжээний өндөр ашигтай ААН-үүдэд зээл олгосон. Гадаадын банк орж ирсний дараа дотоодын банкны зээл системийн хэмжээнд буурсан тул ААН-үүдийн зээл авах магадлал 8 нэгж хувиар буурсан байна. Тус улсын хамгийн өндөр ашигтай ажилладаг ААН-үүдийн 10%-д нь л эерэгээр нөлөөлсөн бол бусдынх нь зээл авах боломж 8%-иар хумигджээ. Улмаар жижиг ААН-үүдийн зээл ихээхэн хэмжээгээр буурч, үйл ажиллагаанд нь сөргөөр нөлөөлсөн байна.
Индонез	<ul style="list-style-type: none"> 2000-аад онд гадаадын банкууд тус улсын дотоод зах зээлээс харьцангуй тааламжтай нөхцөлөөр эх үүсвэр татаж, зөвхөн хамгийн ашигтай томоохон ААН-үүдэд зээл олгож байв. Индонезийн төрийн өмчит банкууд нийт зээлийнхээ 29%, дотоодын хувийн банкууд 19%, гадаадын банкууд ердөө 4%-ийг ЖДҮ-д олгож байсан байна.
БНСУ	<ul style="list-style-type: none"> 1997 оны Азийн хямралын дараа тус улсын иргэд, ААН-үүд харилцах, хадгаламжаа дотоодын банкнаас гадаадын банкинд шилжүүлж байв. Үндэсний банкууд нь байгууллагын зах зээлээ алдаж, ЖДҮ, хэрэглээ болон бичил санхүүгийн зах зээл дээр өрсөлдөж эхэлсэн байна.
Пакистан	<ul style="list-style-type: none"> Жижиг, дунд зээлдэгчдийн мэдээллийг олж авах, түүнтэй холбоотой удирдлагын зардал өндөр байсан тул гадаадын банкууд мэдээлэл багатай ААН-үүдэд зээл олгоогүй байна.
Бага болон бага дунд орлоготой орнууд	
Бага, бага-дунд орлоготой 89 улс	<ul style="list-style-type: none"> Гадаадын банкууд мэдээлэл багатай харилцагчдыг хянахад хүндрэлтэй байсан тул гадаадын банк орж ирснээр эдгээр төрлийн харилцагчид, цаашлаад нийт банкны салбар, э/з-ийн өсөлтөд сөргөөр нөлөөлсөн байна. Гадаадын банкуудын зээлийн багц харьцангуй бага эрсдэлтэй байсан байна.

3.2. МОНГОЛ УЛСЫН МАКРО ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ

Монгол Улсад орж ирэхийг сонирхож буй БНХАУ-ын банкуудын эдийн засагт үзүүлэх нөлөөг гадаадын шууд хөрөнгө оруулалтын (ГШХО) эдийн засагт үзүүлэх нөлөөллөөр төлөөлүүлэн авч үзэж болно.

Тус банкуудын хувьд дотоодын банкуудтай өрсөлдөхөөс илүүтэй хөрөнгө оруулалтын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх сонирхолтой бөгөөд “Хөрөнгө оруулалтын банкны тухай хууль”-ийн төслийн дагуу гадаадын банк нь зөвхөн хөрөнгө оруулалтын банкны үйлчилгээ үзүүлэх боломжтой байна.

Өнөөгийн байдлаар өндөр ашигтай, гадаадын банкны сонирхлыг татахуйц томоохон төслүүд нь гол төлөв уул уурхайн төслүүд байгаа, мөн олон улсын банк, санхүүгийн байгууллагуудаас Монгол улсад 2007 оноос хойш олгосон зээлийн дийлэнх хэсгийг уул уурхайн аж ахуйн нэгжүүдэд олгосон байгаа тул БНХАУ-ын банкуудын богино хугацааны нөлөөг уул уурхайн салбар дахь ГШХО-ын эдийн засагт үзүүлэх нөлөөгөөр төлөөлүүлэх авч үзлээ.

Хөрөнгө оруулалтын чиглэлээр гадаадын банк орж ирснээр Монгол улсын эдийн засагт *богино хугацаанд* бий болох үр дагаврыг бодит тоон өгөгдөл ашиглан тооцоход дараах үр дүнд хүрсэн болно.

- Төсөл хөтөлбөрүүд хэрэгжиж экспорт, гадаадын хөрөнгө оруулалт нэмэгдсэнээр эдийн засгийн өсөлт хурдсах;
- Валютын урсгал сайжирснаар төгрөгийн нэрлэсэн ханш сулрах дарамт буурч, ханш харьцангуй тогтворжих;
- Эдийн засаг дахь нийт эрэлт нэмэгдсэнтэй холбоотойгоор инфляци бага зэрэг өсөх (төсөв, мөнгөний бодлого тэлсэн тохиолдолд инфляци улам ихээр өсөх);

- Үүний эсрэг төв банк инфляцийг бууруулах, нам дор түвшинд хадгалахын тулд бодлогын хүүгээ нэмэгдүүлэх шаардлага бий болох тул гадаадын банк орж ирсэн хэдий ч зээл, хадгаламжийн хүү буурахгүй байх магадлалтай (Өмнөх жилүүдийн буюу халалтын үеийн сургамж).

Мөн Үндэсний статистикийн хорооны 2010 оны орц-гарцын хүснэгтэд үндэслэсэн тооцоо судалгаагаар:

- Уул уурхайн салбарын ГШХО 1%-иар нэмэгдэхэд бодит ДНБ-ий өсөлт дунджаар 1.5 нэгж хувиар нэмэгддэг байна. Өөрөөр хэлбэл, Монгол улсад гадаадын банк орж ирэх нь богино хугацаанд бодит эдийн засгийн идэвхжлийг дэмжиж өсөлтийг бий болгоно.

Гадаадын банкны зээлийн хүүнд үзүүлэх нөлөөллийг тооцсон эмпирик шинжилгээний үр дүнд гадаадын банк орж ирснээр:

- Аж ахуйн нэгжүүдэд харьцангуй бага хүүтэй гадаад валютын зээлийг олгож, гадаад валютын зээлийн хүү буурах;
- Гадаад валютын урсгал сайжирч, төгрөгийн ханшийн сулрах хүлээлт болон эрсдэл буурснаар төгрөгийн зээлийн эрэлт саарч, төгрөгийн зээлийн хүү буурах нөхцөл бүрдэх боломжтой.

4 БНХАУ-ЫН ТУРШЛАГА

4.1. ГАДААДЫН БАНКНЫ ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

БНХАУ-ын Засгийн газраас гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих, санхүүгийн зах зээлийн хууль эрх зүйн орчинг сайжруулах, уян хатан нээлттэй нөхцөлийг бүрдүүлэх, банкны салбарыг либералчлах зэрэгт анхаарлаа хандуулсаар байна. 2001 оны байдлаар 2 хотод л гадаадын банк үйл ажиллагаа эрхэлж байсан бол энэ тоо огцом өсч 2014 онд гадаадын банкны 946 салбар нэгж, охин компаниуд үйл ажиллагаа эрхэлж байна.

Банкны үйл ажиллагаа нь дараах хууль эрх зүйн актаар зохицуулагддаг байна:

- Төв банкны тухай хууль, Банкны тухай хууль, Банкны салбарын зохицуулалтын тухай хууль гэсэн үндсэн 3 хуулийн хүрээнд;
- Төрийн зөвлөлөөс батлагдсан эрх зүйн актуудын хүрээнд (Тухайлбал, Гадаадын хөрөнгө оруулалттай банкуудад эрх олгох тухай);
- Банкны Зохицуулах Хорооноос баталсан дүрэм, журмын хүрээнд.

Түүний зэрэгцээ ОУВС, Европын Сэргээн босголтын банк болон бусад олон улсын санхүүгийн корпорациудтай хийсэн гэрээний хүрээнд тэдгээрийн зөвлөмж, зааварчилгааг мөрдлөг болгохоор үүрэг хүлээсэн байдаг байна.

2015 онд Гадаадын хөрөнгө оруулалттай банкинд зөвшөөрөл олгох журамд өөрчлөлт оруулж, уян хатан, таатай нөхцөлийг бүрдүүлж өгсөн. Тухайлбал:

- Хөрөнгө оруулалт хэлбэрээр дансандаа байршуулах 100 сая юанийн (буцаан үл авах) шаардлагыг байхгүй болгосон;

- Төлөөлөгчийн газар нь 2-оос дээш жил үйл ажиллагаа эрхэлсэн тохиолдолд банкны салбар, охин компани байгуулах зохицуулалттай байсныг хүчингүй болгож шууд зөвшөөрөл авах боломжтой болсон.
- Юаниар хийх банкны үйлчилгээ эрхлэх тохиолдолд санхүүгийн зах зээлд 3 жил банкны үйл ажиллагааг ашигтай эрхэлсэн байх гэсэн шаардлагыг зөөлрүүлж 1 жил болгосон.

“Гадаадын хөрөнгө оруулалттай банкны тухай хууль” болон “Гадаадын хөрөнгө оруулалттай банкны тухай хэрэгжүүлэлт болон холбогдох дүрэм”-ийг үндэслэн, Гадаадын банкны зөвшөөрлийг Банкны Хяналт Шалгалтын хорооноос олгодог. Тус хуулиар зээл, хадгаламж, төлбөр тооцоо, юанийн үйлчилгээ, дүрмийн сангийн доод хэмжээ, банк байгуулах хүсэлтийг хүлээн авах хугацаа, зөвшөөрөл олгох хугацаа зэрэг тусгай шаардлагууд зохицуулагдсан байдаг.

4.2. БНХАУ-ЫН БАНКУУДЫН ГАДААДАД ЯВУУЛЖ БУЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

БНХАУ-ын төрийн бодлогын банкууд нь гадаадад урт хугацааны санхүүжилт олгож гадаад эрэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр ажилладаг бол арилжааны банкууд нь иргэд, аж ахуйн нэгжүүдийн гадаадад явуулж буй үйл ажиллагаанд санхүүгийн үйлчилгээ үзүүлэхэд голчлон чиглэдэг байна. Төрийн бодлогын банкууд буюу Хөгжлийн банк, Экспорт Импорт банк, ХАА-н банк нь Ази, Африк, Өмнөд Америкийн орнуудад урт хугацааны хүү багатай хөгжлийн санхүүжилт олгодог.

Хүснэгт 5: “Bank of China”-ийн гадаад дахь үйл ажиллагаа

Улс	Огноо	Хэлбэр, актив	Үйл ажиллагааны төрөл, чиглэл
Австрали	1990	9 салбар, охин компани (20 тэрбум \$)	<ul style="list-style-type: none"> ▪ Худалдааны санхүүжилт, банкны баталгаа ▪ Хадгаламж, валют арилжаа, клиринг ▪ Ипотек, худалдаа, бүтээн байгуулалт, синдикат зээл ▪ Валютын арилжаа, спот болон форвард арилжаа
Казахстан	1993	Охин компани (514 сая \$)	<ul style="list-style-type: none"> ▪ ААН-ийн зээл (Libor+3%-18% хүүтэй) ▪ Хадгаламжийн даатгал, шилжүүлэг
Вьетнам	1995	1 салбар (17 тэрбум \$)	<ul style="list-style-type: none"> ▪ Ипотекийн зээл (салбарын нийт зээлийн 4.5%) ▪ Худалдааны санхүүжилт, баталгаа, даатгал, синдикат зээл ▪ Хадгаламж, валютын арилжаа
Унгар	2003	1 салбар (18.7 тэрбум \$)	<ul style="list-style-type: none"> ▪ Зээлийн үйлчилгээ (харьцангуй бага) ▪ Хадгаламж, валютын арилжаа, шилжүүлэг ▪ Шилжүүлэг, ЗГ-ын болон юанийнн бондын жуулчлал ▪ Ипотекийн зээл, худалдаа, болон синдикат зээл
Тайланд	1997	5 салбар (1.53 тэрбум \$)	<ul style="list-style-type: none"> ▪ Хадгаламж, валют арилжаа, карт, шилжүүлэг ▪ Иргэд, ипотек, ААН-ийн зээл, синдикат зээл ▪ Валютын арилжаа, спот болон форвард арилжаа ▪ Худ.санхүүжилт, хөрөнгийн үйлчилгээ

Санхүүжилт олгож буй улсдаа ямар нэгэн бодлогын өөрчлөлт хийхийг шаарддаггүй тул Хятадын банкнаас зээл авахыг илүүд үзэх болжээ. Латин Америк, Африкийн орнуудад олгосон санхүүжилтийн хэмжээ нь Дэлхийн банкныхаас давсан байна. Хятадын нийт 18 арилжааны банк гадаадын 51 улс, тэр дундаа уул уурхайд түшиглэсэн Африк, Ойрхи Дорнод, Латин Америк, Канад, Австрали зэрэг улсуудад 1.2 их наяд доллартой тэнцэх хэмжээний актив бүхий 1127 компаниар дамжуулан үйл ажиллагаа явуулж байна.

БНХАУ-ын хөгжлийн стратеги болох “ One Belt, One Road (Нэг бүс, нэг зам)” санаачилга, “Going Global (Дэлхийд гарах)” стратеги болон Юанийг олон улсын валют болгох зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд тус улсын дэлхийд тэргүүлэгч төрийн өмчит 2 банк болох “Bank of China” болон ICBC (Хятадын Үйлдвэр Худалдааны банк) нь олон улсын санхүүгийн салбарт онцгойлон идэвхтэй ажиллаж байна.

5 ДҮГНЭЛТ, ЦААШИД АНХААРАХ АСУУДЛУУД

Олон улсын туршлага, харьцуулсан судалгаа шинжилгээ болон Монгол улсын эдийн засаг, санхүүгийн салбарын өнөөгийн хөгжлийг харгалзан гадаадын банкууд манай улсад үйл ажиллагаа явуулахад хууль эрх зүйн орчин, эдийн засаг болон санхүүгийн салбарын хүрээнд хэд хэдэн зүйлсийг анхаарах шаардлагатай байна.

Хууль эрх зүйн орчны хүрээнд:

Монгол улсын санхүүгийн зах зээл дээр хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, тогтоомж болон эрх зүйн актын хүрээнд гадаадын банк, түүний нэгжийн эрхлэх үйл ажиллагаа, зөвшөөрөл олгох, тавигдах шаардлага, татгалзах үндэслэл, хяналт тавих асуудлууд зохицуулагдах боломжтой байна.

Дотоодын санхүүгийн зах зээлийг учирч болзошгүй эрсдэлээс хамгаалах, аливаа нэг гадаад банкинд давамгайл байдал үүсгэхгүй байх, гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээг тэнцвэртэй байлгах бодлогыг хэрэгжүүлэх зорилгын хүрээнд гадаадын банкны актив хөрөнгө, тусгай зөвшөөрөл авсан үйл ажиллагаанд тавих хяналт, зохицуулалтын чиглэлээр Банкны тухай хуулийн 22.2-т заасны дагуу холбогдох эрх зүйн актыг боловсронгуй болгох нь зүйтэй. Үүний зэрэгцээ дараах зүйлсийг анхаарах шаардлагатай байна. Үүнд:

- “Гадаадын банк” гэсэн нэр томъёолол, түүний тодорхойлолтыг нэг мөр тодорхой болгох (Гадаадын хөрөнгө оруулалттай банк, эсхүл 100 хувь гадаад улсын гадаад банкнаас үүсгэн байгуулагдсан банк гэх мэт);
- Гадаадын банкны эрхлэх үйл ажиллагааны хязгаарлалтыг тухайн гадаадын банкны өмчлөлийн төрлөөр нь ялгаатай тогтоох;
- Гадаадын банк Монгол улсын санхүүгийн зах зээлд банкны үйл ажиллагаа эрхлэх тохиолдолд тухайн банкны хяналт шалгалтыг хэрэгжүүлдэг эрх бүхий байгууллагатай тухайн банкиг хянах хяналтын эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгох;

- Зээлийн мэдээллийн сангийн эрх зүйн зохицуулалтыг бий болгох;
- Давхар татварын эрх зүйн зохицуулалтын хүрээнд аливаа гадаадын банк нь Монгол улсад банкны үйл ажиллагаа эрхлэх тохиолдолд зөвхөн “Охин компани” буюу хуулийн этгээдийн хэлбэрээр үйл ажиллагаа эрхлэх;
- Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг гадаадын банкны эрхлэх үйл ажиллагаанд нь тохируулан оновчтой тогтоох (зээлийн хязгаарлалт, хувь нийлүүлсэн хөрөнгийн дээд хязгаар гэх мэт);
- Гадаадын банкны үйл ажиллагаа тус бүр дээр тодорхой хязгаарлалтаас гадна хугацаа тогтоох эсэх асуудлыг авч үзэх;
- Гадаадын болон дотоодын банкуудын эрх, ашгийг тэнцвэржүүлсэн зарчмыг баримтлах хүрээнд Монгол улсын онцлог, нийгэм-эдийн засгийн нөхцөлтэй уялдуулан гадаадын банкны үйл ажиллагааг төрөлжсөн байдлаар тодорхой хүрээнд чиглүүлэх нь зүйтэй байна.

Эдийн засгийн хүрээнд:

Монгол улсын санхүүгийн салбарт гадаадын банк үйл ажиллагаа явуулснаар дотоодын эдийн засагт дараах эерэг үр дагавар бий болох боломжтой байна.

- Эдийн засгийн хүндрэлтэй өнөө үед гадаадын хөрөнгө оруулалт нэмэгдэж, зээл олголт өссөнөөр бизнесийн идэвхжил сэргэх боломж бүрдэнэ.
- Гадаадын банкны санхүүжилтээр томоохон төсөл, хөтөлбөрүүд хэрэгжих тохиолдолд эдийн засгийн эргэлтэд орсноор экспорт өсч, төлбөрийн тэнцэл сайжирна.
- Төгрөгийн ханш тогтворжиж, гадаад валютын нийлүүлэлт нэмэгдсэнээр гадаад валютын нөөц бүрдэх боломж бий болно.
- Бага өртөгтэй гадаад эх үүсвэрийн нийлүүлэлт, банкны салбарын эрүүл өрсөлдөөн бий болсон тохиолдолд зээлийн хүү буурах нөхцөл бүрдэнэ.

Гэвч гадаадын банкууд орж ирснээр дунд, урт хугацаанд дотоодын эдийн засаг, макро бодлогын хүрээнд дараах зүйлсийг анхаарах шаардлагатай байна.

- Олон улсын санхүүгийн зах зээлийн шокод өртөмтгий, эмзэг байдлыг нэмэгдүүлэх эрсдэлтэй.
- Эдийн засгийн хүндрэлтэй үед гадаадын банкууд үйл ажиллагаагаа хумьж, зогсоосноор зээлийн тасалдал бий болох улмаар хүндрэлийг гүнзгийрүүлэх эрсдэлтэй.
- Мөнгөний бодлогын үр ашиг, бодлогын хүүний нөлөөллийн хүчийг сулруулах эрсдэлтэй.
- Төсвийн бодлогын тэлэлтээс үүдэн эдийн засагт сөрөг үр дагаврууд бий болох эрсдэлтэй.

Гадаадын банкны Монгол улсын эдийн засагт бий болгох өгөөжийг нэмэгдүүлэх, макро эдийн засгийн тогтвортой байдал, бодлогын үр ашигт байдалд үзүүлэх боломжит сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэхийн тулд:

- Гадаадын банкууд дотоодын эдийн засгийн хэт халалтыг бий болгох, хүндрэлийг гүнзгийрүүлэхээс сэргийлсэн зохицуулалтын арга хэмжээ тогтмол авч хэрэгжүүлж байх (макро болон микро зохистой бодлого),
- Гадаадын банкууд ихэвчлэн томоохон төсөл, аж ахуйн нэгжүүдэд хөрөнгө оруулалт хийх хандлагатай байдаг тул тэднийг жижиг, дунд аж ахуйн нэгжүүдийн мэдээллээр хангаж, тэдний үйл ажиллагааг дэмжих бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэх,
- Гадаадын хөрөнгийн урсгал сайжирч, ханш тогтворжин, орлого нэмэгдэх тохиолдолд төсвийн бодлогыг тэлэхээс сэргийлж нөөц санд хуримтлал бий болгох, мөнгөний бодлогыг эдийн засгийн өсөлтийг дэмжих, тогтвортой байдлыг хадгалахад чиглүүлэх, гадаад валютын нөөцийг нэмэгдүүлж гадаад өрийн дарамтыг бууруулах арга хэмжээ авах нь зүйтэй.

Санхүүгийн салбарын хүрээнд:

Гадаадын банкуудын оролцоо, зах зээлд эзлэх хувь, хэмжээнээс хамаарч дотоодын банкуудын өрсөлдөөн, зээлийн хүү, үр ашигт байдал, ашигт ажиллагаанд ялгаатай нөлөө үзүүлнэ.

Гадаадын банкууд манай улсын санхүүгийн салбарт орж ирснээр дараах эерэг нөлөөллүүдийг үзүүлэх боломжтой. Тухайлбал:

- Банкны салбарын өрсөлдөөнийг эрчимжүүлж, банкуудын үр ашгийг сайжруулан, санхүүгийн зуучлалын өртгийг (хүү) бууруулах боломжтой.
- Шинэ технологи, шинэ бүтээгдэхүүн, шинэ үйлчилгээ нэмэгдсэнээр санхүүгийн хүртээмж дээшлэх боломж бүрдэнэ.
- Гадаадын банкуудын оролцоо нэмэгдсэнээр банкны салбарын төвлөрөл саарна.
- Гадаадын банкууд зөвхөн банкны салбарын зээлийн нийлүүлэлтээс гадна хөрөнгийн зах зээлээр дамжин санхүүжилтийг олгох тохиолдолд санхүүгийн гүнзгийрлийг нэмэгдүүлэх нөлөөтэй.

Түүний зэрэгцээ дотоодын санхүүгийн зах зээл болон банкуудын үйл ажиллагаанд дараах хүндрэлүүдийг учруулж болзошгүй байна. Үүнд:

- Богино хугацаанд дотоодын банкуудын ашигт ажиллагаанд нь сөргөөр нөлөөлнө.
- Гадаадын банкууд зөвхөн томоохон ААН-д зээл олгох хандлагатай байдаг тул жижиг, дунд ААН-ийн хувьд зээлийн хүртээмж төдийлөн өсөхгүй, хүү нь дорвитой буурахгүй байх талтай.
- Дотоодын зах зээлд эерэг гадаадын банкуудын оролцоо хэт ихсэх нь урт хугацаанд цөөн тооны гадаадын банкуудаас хараат болох эргээд төвлөрлийг нэмэгдүүлэх эрсдэлтэй.
- Дотоодын хөрөнгийн зах зээл дээр гадаадын банкуудын оролцоо нэмэгдэх нь стратегийн ач холбогдолтой томоохон төслүүдийг эрхшээлдээ оруулж ноёрхлоо тогтоох эрсдэлтэй.
- Дотоодын зах зээлд өрсөлдөөн эрчимжсэнээр банкуудын зээлийн нөхцөл, шаардлага суларч салбарын хэмжээнд чанаргүй зээл өсөх эрсдэлийг нэмэгдүүлнэ.

Дотоодын банк, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хадгалах, гадаад зах зээлийн сөрөг шокуудад өртөмтгий болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор дараах бодлогын арга хэмжээг авах нь зүйтэй.

- Гадаадын банк орж ирэх хууль эрх зүйн таатай орчинг бүрдүүлэх, үйл ажиллагааг тодорхой болгож зохих хязгаарлалт, зохицуулалтыг хийх шаардлагатай.

- Гадаадын банкуудын дотоодын зах зээлд эзлэх хувь хэмжээг тодорхой түвшинд хязгаарлах бодлого баримтлах (Хөгжиж буй орнуудын хувьд нийт банкны салбарын дунджаар 45%-ийг гадаадын банкууд эзэлж байна).
 - Гадаадын банкуудын үйл ажиллагааны төрөлжилтийг үйл ажиллагаа эрхлэх хугацаатай нь уялдуулан тогтоох, тодорхой хугацааны дараа дотоодын банкуудын өрсөлдөх чадвар сайжирсан үед гадаадын банкуудын үйл ажиллагааны төрөлжилтийн хязгаарлалтыг сулруулах.
- Үндэсний аюулгүй байдлын хүрээнд:**
- Дотоодын макро бодлогыг хүчгүйдүүлэх, мөнгөний бодлогын нөлөөг сулруулах эрсдэлтэй бөгөөд гадаадын банкуудын үйл хөдлөл, шийдвэр нь илүү хүчтэй нөлөөтэй болох тул дотоодын бодлогыг хамгаалах чиглэлд анхаарч ажиллах.
 - Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.2.2.2-т *"Гадаадын аль нэг орноос хийгдэх хөрөнгө оруулалтын хувь, хэмжээг гадаадын нийт хөрөнгө оруулалтын гуравны нэгээс хэтрэхгүй байлгах, стратегийн ач холбогдолтой салбарт хөрш орон, өндөр хөгжилтэй бусад орноос оруулах хөрөнгө оруулалтын хэмжээг тэнцвэртэй байлгах бодлого баримтална"* гэсэн заалтыг хангуулахын тулд бусад олон улсын банк, санхүүгийн байгууллага, хөгжингүй орнуудаас татах хөрөнгө оруулалтын хувь, хэмжээнд анхаарах.
 - Гадаадын улс орнууд банк, санхүүгийн салбараар дамжуулан стратегийн ач холбогдолтой томоохон төслүүдийг эзэмших нь Монгол улсын эдийн засгийн бие даасан байдалд сөргөөр нөлөөлөх аюултай тул стратегийн ач холбогдол бүхий төслүүдэд оруулах хөрөнгө оруулалтын хувь, хэмжээг хязгаарлах, зохицуулах.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Acheampong, N. K. (2013). The effects of foreign bank entry on financial performance of domestic-owned banks in Ghana. *The International Journal of Business and Finance Research*, 7(3), 93-104.
- Beck, T., & Martinez Peria, M. (2010). Foreign bank acquisitions and outreach: Evidence from Mexico. *Journal of Financial Intermediation*, 19, 52-73.
- Beck, T., Levine, R., & Loayza, N. (2000). Finance and the Sources of Growth. *Journal of Financial Economics*, 58(1), 261-300.
- Bekaert, G., Harvey, C. R., & Lundblad, C. (2005). Does financial liberalization spur growth? *Journal of Financial Economics*, 77(1), 3-55.
- Berger, A. N., & DeYoung, R. (2001). The effects of geographic expansion on bank efficiency. *Journal of Financial Services Research*, 19(2-3), 163-184.
- Berger, A. N., & DeYoung, R. (2006). Technological progress and the geographic expansion of the banking industry. *Journal of Money, Credit and Banking*, 38(6), 1483-1513.
- Berger, A. N., Klapper, L. F., & Udell, G. F. (2001). The ability of banks to lend to informationally opaque small businesses. *Journal of Banking & Finance*, 25(12), 2127-2167.
- BIS. (2001). *The banking industry in the emerging market economies: competition, consolidation and systemic stability*. BIS Papers no. 4.
- BIS. (2006). *The banking system in emerging economies: How much progress has been made?* BIS Papers no. 28.
- Bonin, J. P., Hasan, I., & Wachtel, P. (2005). Privatization matters: Bank efficiency in transition countries. *Journal of Banking & Finance*, 29(8), 2155-2178.
- Broecker, T. (1990). Credit-worthiness tests and interbank competition. *Econometrica*, 58, 429-452.
- Bruno, V., & Hauswald, R. (2014). The real effect of foreign banks. *Review of Finance*, 18, 1683-1716.
- Chen, S.-H., & Liao, C.-C. (2011). Are foreign banks more profitable than domestic banks? Home- and host-country effects of banking market structure, governance, and supervision. *Journal of Banking & Finance*, 35(4), 819-839.
- Chui, M. K., Domanski, D., Kugler, P., & Shek, J. (2010). *The collapse of international bank finance during the crisis: Evidence from syndicated loan markets*. BIS Quarterly Review.
- Claessens, S., & Laeven, L. (2003). Financial development, property rights, and growth. *The Journal of Finance*, 58(6), 2401-2436.
- Claessens, S., Demirgüç-Kunt, A., & Huizinga, H. (2001). How does foreign entry affect domestic banking markets? *Journal of Banking & Finance*, 25(5), 891-911.
- De Bandt, O., & Davis, E. P. (2000). Competition, contestability and market structure in European banking sectors on the eve of EMU. *Journal of Banking & Finance*, 24(6), 1045-1066.
- Dell'Ariccia, G., & Marquez, R. (2004). Information and bank credit allocation. *Journal of Financial Economics*, 72(1), 185-214.
- Dell'Ariccia, G., Friedman, E., & Marquez, R. (1999). Adverse selection as a barrier to entry in the banking industry. *The RAND Journal of Economics*, 30, 515-534.
- Detragiache, E., Tressel, T., & Gupta, P. (2008). Foreign banks in poor countries: theory and evidence. *The Journal of Finance*, 63(5), 2123-2160.
- Gehrig, T. (1998). Screening, cross-border banking, and the allocation of credit. *Research in Economics*, 52(4), 387-407.
- Giannetti, M., & Ongena, S. (2009). Financial integration and firm performance: Evidence from foreign bank entry in emerging markets. *Review of Finance*, 13(2), 181-223.
- Gopalan, S. (2014). *Monetary and Financial Implications of Foreign Bank Entry in Emerging and Developing Economies*. George Mason University.
- Gormley, T. A. (2010). The impact of foreign bank entry in emerging markets: Evidence from

- India. *Journal of Financial Intermediation*, 19(1), 26-51.
- Gual, J. (1999). Deregulation, Integration, and market structure in European Banking. *Journal of the Japanese and International Economies*, 13(4), 372-396.
- Haber, S. H., & Musacchio, A. (2005). *Foreign banks and the Mexican economy, 1997-2004*. Stanford: Working Paper No. 267, Center for International Development.
- Hamada, M. (2013). *Impact of foreign capital entry in the Indonesian banking sector*. Institute of Developing Economies, JETRO.
- Hasan, I., & Marton, K. (2003). Development and efficiency of the banking sector in a transitional economy: Hungarian experience. *Journal of Banking & Finance*, 27(12), 2249-2271.
- Hauswald, R., & Marquez, R. (2006). Competition and strategic information acquisition in credit markets. *Review of Financial Studies*, 19(3), 967-1000.
- Havrylchyk, Olena and Jurzyk, Emilia. (2011). Inherited or earned? Performance of foreign banks in Central and Eastern Europe. *Journal of Banking & Finance*, 35(5), 1291-1302.
- Hermes, N., & Lensink, R. (2001). *The impact of foreign bank entry on domestic banking markets: A note*. University of Groningen.
- Horen, V., Neeltje, Claessens, & Stijn. (2012). *Foreign Banks: Trends, Impact and Financial Stability*.
- Kalluru, S., & Bhat, S. (2009). Does Foreign Bank Entry Affect Operations of Domestic Banks? A Study on Indian Public Sector Banks. *IUP Journal of Managerial Economics*, 7(3/4), 40.
- Kim, Hyun E and Lee, Byung-Yoon. (2003). *The effects of foreign bank entry on the performance of private domestic banks in Korea*. Bank for International Settlements.
- Lubis, A. W., Bustaman, Y., & Riyanti, R. S. (2015). Foreign Bank Entry and Credit Allocation to SMEs: Evidence from ASEAN Countries. *Procedia-Social and Behavioral Sciences*, 211, 1049-1056.
- Mamonov, M. (2010). Testing for Competition in the Russian Banking Sector within Panzar-Rosse approach: theoretical and empirical framework. *Applied Econometrics*, 20(4), 3-27.
- Manlagcit, M. C. (2011). The economic effects of foreign bank presence: Evidence from the Philippines. *Journal of International Money and Finance*, 30(6), 1180-1194.
- Mian, A. (2006). Distance constraints: The limits of foreign lending in poor economies. *The Journal of Finance*, 61(3), 1465-1505.
- Miklaszewska, E, Mikolajczyk, & K. (2009). Foreign bank entry and bank performance in Poland: Testing the global advantage hypothesis. *Journal of Money, Investment and Banking*, 10, 57-78.
- Naaborg, & Ilko, J. (2007). *Foreign bank entry and performance*. Eburon Uitgeverij BV.
- Petersen, M. A., & Rajan, R. G. (1995). The effect of credit market competition on lending relationships. *The Quarterly Journal of Economics*, 110(2), 407-443.
- Rajan, R. G., & Zingales, L. (1998). Financial dependence and growth. *American Economic Review*, 88, 559-586.
- Rokhim, R., & Susanto, A. (2011). *The increase of foreign ownership and its impact to the performance, competition & risk in Indonesian banking industry*. Competition & Risk in Indonesian Banking Industry.
- Sengupta, R. (2007). Foreign entry and bank competition. *Journal of Financial Economics*, 84(2), 502-528.
- Seo, Jae Ik and Chao, Guan Shi and Park, Sang-Bum. (2013). An Empirical Study on the Impacts of the Chinese Banking Industry by Foreign Banks' Entry. *International Journal of Economics and Finance*, 5(1), 210.
- Serdyuk, A. (2004). *The impact of foreign bank entrance on the domestic bank performance in the countries with transition economy: Case of Russia and Ukraine*. National University "Kyiv-Mohyla Academy" EERC.
- Thi, V., Anh, N., & Vencappa, D. V. (2008). *Does the Entry Mode of Foreign Banks Matter for Bank Efficiency? Evidence from Czech Republic, Hungary, and Poland*. William Davidson Institute Working Paper.
- Tsaruk, A., & Sidenko, M. (2008). *Measuring change in efficiency of banking system in Ukraine due to foreign entry*.
- Unite, A., & Sullivan, M. (2003). The effect of foreign entry and ownership structure on the Philippine domestic banking market. *Journal of Banking & Finance*, 27(12), 2323-2345.
- Weill, Laurent. (2003). Banking efficiency in transition economies. *Economics of transition*, 11(3), 569-592.
- Williams, J., & Nguyen, N. (2005). Financial liberalisation, crisis, and restructuring: A comparative study of bank performance and bank governance in South East Asia. *Journal*

- of Banking & Finance*, 29(8), 2119-2154.
- Xin, Y. (2006). Empirical study on foreign bank entry's influence on Chinese banks' efficiency. *Finance Problems Research*, 2, 61-66.
- Zhengde, Xiong and Lijuan, Hou. (2009). Influence of share-holding of foreign banks on efficiency of commercial banks: analysis based on panel data. *Financial Thoery and Practice*, 3, 19-22.
- А.Хулан. (2004). Банкны салбар дахь гадаадын өмчлөлийн болон төрийн өмчийн банкуудын байр суурийн судалгаа. *Монголбанкны Судалгааны ажил "Товхимол"*, 60-73.
- Г.Борхүү. (2014). Гадаадын хөрөнгө оруулалттай банк Монгол Улсад үйл ажиллагаа явуулахтай холбоотой үүсч болзошгүй эрсдэлүүдийн талаар. *Монголбанкны Судалгааны ажил "Товхимол"*, 9(1), 33-43.
- Д.Мөнхцэцэг, & П.Гантөмөр. (2015). Гадаадын хөрөнгө оруулалтын талаар баримтлах зохистой бодлого. *Монголбанкны Судалгааны ажил "Товхимол"*, 10, 655-724.
- Л.Даваажаргал. (2014). *Гадаадын шууд хөрөнгө оруулалтын шокын эдийн засагт үзүүлэх нөлөөлөл*. Улаанбаатар: Хэвлэгдээгүй ажил.
- С.Билгүүн. (2010). *Банкуудын өмчлөл болон банкны салбар дахь гадаад хөрөнгө оруулалт*. Улаанбаатар: Хэвлэгдээгүй ажил.
- Ч.Хашчулуун, Б.Болор-Эрдэнэ, & Э.Цогбаяр. (2014). *Гадаадын банкны салбар: Монгол Улсын нийгэм-эдийн засагт үзүүлэх нөлөө*. Улаанбаатар: Монголын Банкуудын Холбоо.

